

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хуульчийн мэргэжлийн шалгалт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчийн эрх зүйн байдал, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын тухай, Өмгөөллийн тухай, Нотариатын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."хуульч" гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хүнийг;

3.1.2."хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл" гэж шүүгч, прокуророор ажиллах, нотариатчийн, өмгөөллийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагааг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг;

3.1.3."хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа" гэж шүүгч, прокуророор ажиллах, нотариатчийн, өмгөөллийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг;

3.1.4."хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага" /цаашид "Хуульчдын холбоо" гэх/ гэж хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг;

3.1.5."хуульч эрдэмтэн" гэж энэ хуулийн 18.2-т заасны дагуу бүртгүүлсэн, эрх зүйн дээд боловсролтой, хууль зүйн ухааны, эсхүл шинжлэх ухааны докторын зэрэг бүхий хуульчийг;

3.1.6."хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа" гэж нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн зөвлөгөө өгөх, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилготой үйл ажиллагааг.

#### **4 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах;

4.1.2.хууль дээдлэх, шударга ёсыг сахих;

4.1.3.хараат бус байх;

4.1.4.хүнлэг, энэрэнгүй байх.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ**

#### **5 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн шалгалт**

5.1.Хуульчийн мэргэжлийн шалгалт /цаашид "Хуульчийн шалгалт" гэх/-ын зорилго нь шүүгч, прокуророор ажиллах, нотариатчийн, өмгөөллийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх хангалттай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэнэ.

5.2.Хуульчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд тэгш байдал, шударга ёсыг хангах, ил тод байх, хууль дээдлэх, олон нийтийн итгэлийг даах, хараат бус байх, нууцыг чандлан хадгалах зарчмыг баримтална.

#### **6 дугаар зүйл.Хуульчийн шалгалтын комисс**

6.1.Хуульчийн шалгалтыг энэ хуулийн 50.2.1-д заасны дагуу байгуулагдсан комисс /цаашид "Шалгалтын комисс" гэх/ зохион байгуулна.

6.2.Шалгалтын комисст шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуульч эрдэмтэн, хуулийн зөвлөх болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл орно.

6.3.Шалгалтын комисс доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1.сорилгын болон бодлогын шалгалтад оролцогчдын даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх;

6.3.2.шалгалтад оролцогч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хангалттай итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал тогтсон эсэхийг тодорхойлж, үнэлгээ өгөх;

6.3.3.хуульчийн шалгалтын дүнг үнэн зөв нэгтгэн Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд хүргүүлэх;

6.3.4.шалгалтын даалгаврын боловсруулалт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

6.4.Хуульчийн шалгалтын хураамжийн хэмжээ, хуульчийн шалгалт зохион байгуулах журмыг Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны саналыг үндэслэн Хуульчдын холбооны Зөвлөл батална.

## **7 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад орох эрх**

7.1.Хуульд заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгссөн, хуульчийн шалгалтад орох үед 2 жил, түүнээс доошгүй хугацаанд мэргэжлийн дадлага хийсэн, энэ хуулийн 9.1-д заасан хуульчийн мэргэшлийн сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй.

7.2.Гадаад улсын хууль зүйн сургуулийг энэ хуулийн 7.1-д заасан магадлан итгэмжлэгдсэн сургуультай дүйцүүлэн тооцох журмыг Хуульчдын холбоо батална.

## **8 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн дадлага хийсэн хугацааг тоолох**

8.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуульчийн мэргэжлийн дадлага хийсэн гэдэгт дараахь ажил, албан тушаалд ажилласныг ойлгоно:

8.1.1.шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн туслах;

8.1.2.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид эрх зүйч мэргэжил шаардах үндсэн ажил, албан тушаал;

8.1.3.магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийн багш, туслах багш, төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн судалгааны ажилтан.

8.2.Энэ хуулийн 8.1-д зааснаас гадна өмгөөллийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэхэд туслах ажлыг цагаар болон гэрээгээр гүйцэтгэснийг багц цагт шилжүүлж мэргэжлийн дадлага хийсэнд тооцож болно.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан мэргэжлийн дадлага хийсэн хугацаа болон гадаад улсад энэ хуулийн 8.1-д заасан ажил, албан тушаалд ажилласан хугацааг мэргэжлийн дадлага хийсэн хугацаанд тооцох журмыг Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны саналыг үндэслэн Хуульчдын холбооны Зөвлөл батална.

## **9 дүгээр зүйл.Хуульчийн мэргэшлийн сургалт**

9.1.Хуульч болох хүсэлтэй, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийн төгсөгч төгсөлтийн дараахь сургалт эрхлэх хөтөлбөр бүхий хууль зүйн сургуульд 18 сараас багагүй хугацаагаар хуульчийн мэргэшлийн сургалтад хамрагдсан байна.

9.2.Мэргэшлийн сургалтын үйл ажиллагаанд Хуульчийн холбоо арга зүйн дэмжлэг үзүүлэх бөгөөд мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтыг төгсөгчид олгох гэрчилгээний загвар, мэргэшүүлэх сургалтын зардлын жишгийг Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудлыг эрхэлсэн хорооны саналыг үндэслэн Хуульчдын Холбооны зөвлөл батална.

9.3.Энэ хуулийн 9.1-д заасан хуульчийн мэргэшлийн сургалтад элсэн суралцах эрх зүйчид тавигдах голч дүнгийн шаардлагыг Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудлыг эрхэлсэн хороо 5 жил тутамд тогтооно.

9.4.Хуульчийн мэргэшлийн сургалтыг хууль зүйн сургууль эрхлэн зохион байгуулах бөгөөд түүний агуулга, стандартад Хуульчдын холбоо энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу хяналт тавина.

## **10 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад орох тухай хүсэлт гаргах**

10.1.Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан этгээд хуульчийн шалгалтад орох тухай хүсэлтээ Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд гаргана.

10.2.Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо энэ хуулийн 13.4-т заасан хугацаанд хүсэлт хүлээн авна.

10.3.Хуульчийн шалгалтад орох тухай хүсэлтэд доор дурдсан баримт бичгийг хавсаргана:

10.3.1.Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын иргэний үнэмлэх болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар;

10.3.2.эрх зүйч мэргэжлийн боловсролын дипломын хуулбар;

10.3.3.хуульчийн мэргэшлийн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

10.3.4.мэргэжлийн дадлага хийснийг нотлох баримт бичиг;

10.3.5.мэргэшлийн сургалтад хамрагдсныг нотлох баримт бичиг;

10.3.6.Хуульчдын холбооноос баталсан маягтын дагуу гаргасан хүсэлт гаргагчийн мэдээлэл;

10.3.7.сэтгэцийн эмгэггүйг нотолсон тодорхойлолт.

10.4.Шалгалтын комисс хуульчийн шалгалтад орох тухай хүсэлт, энэ хуулийн 10.3-т заасан мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг гаргуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй бөгөөд энэ хуулийн 10.3-т заасан баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулгаж, баталгаажуулна.

10.5.Шалгалтын комисс хүсэлт гаргагч санаатай гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байсан эсэх талаархи тодорхойлолтыг холбогдох байгууллагаас гаргуулан авна.

10.6.Хүсэлт гаргагч энэ хуулийн 8.1-д заасан мэргэжлийн дадлага хийсэн эсэхээ өөрөө нотлох үүрэгтэй.

### **11 дүгээр зүйл.Хуульчийн шалгалтад орох тухай хүсэлтийг шийдвэрлэх**

11.1.Доор дурдсанаас бусад тохиолдолд хүсэлт гаргагчийн хуульчийн шалгалтад орох эрхийг жагсаалтаар баталгаажуулж, нийтэд мэдээлнэ:

11.1.1.хүсэлт гаргагч энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг хангаагүй;

11.1.2.энэ хуулийн 10.3-т заасан баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

11.1.3.хүсэлт гаргагчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр байгаа;

11.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай хүчингүй болгосон хугацаа дуусаагүй.

11.1.5.Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дуусаагүй;

11.1.6.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан.

### **12 дугаар зүйл.Жагсаалтад бүртгэхээс татгалзсан шийдвэрт гомдол гаргах**

12.1.Хүсэлт гаргагч нь хуульчийн шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульчийн шалгалт эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд гомдол гаргах эрхтэй.

12.2.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо хуульчийн шалгалт эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гомдлыг эцэслэн шийдвэрлэнэ.

12.3.Хүсэлт гаргагч энэ хуулийн 12.2-т заасан заасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

### **13 дугаар зүйл.Хуульчийн шалгалт явуулах газар, хугацаа**

13.1.Хуульчдын холбоо хуульчийн шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

13.2.Хуульчийн шалгалтын товыг уг шалгалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

13.3.Хуульчийн шалгалтын товд шалгалтын хуваарь, бүртгэх журам, шалгалт авах газар, хугацаа, шалгалтын дарааллыг заана.

13.4.Хуульчийн шалгалтад оролцогчийг бүртгэх ажиллагаа шалгалтын товыг зарласан өдрөөс эхэлж, шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө дууссан байна.

### **14 дүгээр зүйл.Хуульчийн шалгалтын даалгавар**

14.1.Шалгалтын комисс хуульчийн шалгалтын даалгаврын нууцлалыг шалгалт эхлэх хүртэл, түүний хариултын нууцлалыг шалгалт дуусах хүртэл хамгаална.

14.2.Хуульчийн шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох шалгалтад оролцогчийн нэр нууцлагдсан байна.

### **15 дугаар зүйл.Хуульчийн шалгалт авах журам**

15.1.Хуульчийн шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэгийг сорьсон сорилгын, эрх зүйн салбарын хүрээнд тодорхой тохиолдлыг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал тогтсон эсэхийг тодорхойлох шалгалтын хэлбэрээр явагдана.

15.2.Хуульчийн шалгалтад оролцогч сорилгын шалгалтын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан бол бодлогын шалгалтад орох эрхтэй болно.

15.3.Сорилгын болон бодлогын шалгалтад авсан нийлбэр дүн нь хуульчийн шалгалтын нийт онооны 70 ба түүнээс дээш хувьд хүрсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хангалттай итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал тогтсон гэж үнэлэгдсэн бол хуульчийн шалгалтад тэнцсэнд тооцно.

15.4.Шалгалтын комисс хуульчийн шалгалтын нэгдсэн дүнг шалгалт дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан шалгалтад оролцогчдын нэрсийн жагсаалтад харгалзах тоон дугаараар гаргаж, нийтэд мэдээлнэ.

#### **16 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад тэнцсэн тухай батламж олгох**

16.1.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо хуульчийн шалгалт дууссанаас хойш 30 хоногийн дотор хуульчийн шалгалтад тэнцсэн этгээдэд батламж олгоно.

#### **17 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад дахин орох**

17.1.Хуульчийн шалгалтад тэнцээгүй тохиолдолд 1 жилийн дотор дахин орох эрхгүй.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ**

#### **18 дугаар зүйл.Хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэж, хуульчийн зөвшөөрөл олгох**

18.1.Хуульчийн шалгалтад тэнцэж батламж авсан этгээд батламж авсан өдрөөс хойш 1 жилийн дотор хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, Хуульчдын холбоонд гишүүнээр элсэх хүсэлт гаргана.

18.2.Хуульч эрдэмтэн Хуульчдын холбоонд гишүүнээр элсэх хүсэлт гаргасан тохиолдолд хуульчийн шалгалтад орсон байхыг шаардахгүй.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан хүсэлтэд хуульчийн шалгалтад тэнцсэн батламжийг хавсаргана.

18.4.Хуульчдын холбоо хүсэлт гаргагчийг гишүүнээр элсүүлэх бол хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /цаашид “хуульчийн зөвшөөрөл” гэх/ хугацаагүй олгоно.

18.5.Хуульчдын холбооны Зөвлөл хуульчдын нэгдсэн бүртгэлийг хөтлөх журмыг батална.

#### **19 дүгээр зүйл.Хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх**

19.1.Доор дурдсан тохиолдолд хүсэлт гаргагчид хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлнэ:

19.1.1.хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдан эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;

19.1.2.хүсэлт гаргагч нь эрүүл мэндийн байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон;

19.1.3.энэ хуулийн 10.3-т заасан баримт бичигтэй холбоотой маргаан үүссэн;

19.1.4.хүсэлт гаргагч төрийн улс төрийн албан тушаал эрхэлж байгаа;

19.1.5.хүсэлт гаргагч цэргийн алба биеэр хааж байгаа, эсхүл цэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах мэдэгдэл авсан.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл арилсан бол хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэх ажиллагааг ердийн журмаар явуулна.

## **20 дугаар зүйл.Хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл**

20.1.Доор дурдсан тохиолдолд хүсэлт гаргагчид хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзана:

20.1.1.санаатай гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох тухай шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон;

20.1.2.энэ хуулийн 10.3-т заасан баримт бичиг нь хуурамч болох нь тогтоогдсон;

20.1.3.энэ хуулийн 11.1-д заасан үндэслэл шинээр илэрсэн.

20.2.Хүсэлт гаргагч хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

## **21 дүгээр зүйл.Хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

21.1.Доор дурдсан тохиолдолд хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

21.1.1.эрүүл мэндийн, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон;

21.1.2.улс төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон, улс төрийн нам, эвсэлд орон тооны, эсхүл сонгуульт албан тушаал эрхлэх болсон.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан үндэслэл арилсан бол хуульчийн зөвшөөрлийг сэргээх хүсэлт гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1-д заасан үндэслэлээр хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч гаргана.

21.4.Хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хуульчийг Хуульчдын холбооны гишүүний хураамж төлөх үүргээс чөлөөлнө.

## **22 дугаар зүйл.Хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгох**

22.1.Доор дурдсан тохиолдолд хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгоно:

22.1.1.хуульчийн зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

22.1.2.хуульчаар ажиллаж байх хугацаандаа санаатай гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон;

22.1.3.хууль, Хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн үндэслэлээр хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон;

22.1.4.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуульд заасан үргэлжилсэн сургалтын багц цагийг хангах үүргээ 3 жил, түүнээс дээш хугацаагаар биелүүлээгүй;

22.1.5.энэ хуулийн 28.1.3-т заасан гишүүний хураамж төлөх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 6 сар дараалан, эсхүл хуульчаар ажиллах хугацаандаа нийт 1 жил, түүнээс дээш хугацаагаар биелүүлээгүй;

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан үндэслэлээр Хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэрийг Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо гаргана.

## **23 дугаар зүйл.Хуульчийн зөвшөөрлийг дуусгавар болох**

23.1.Доор дурдсан тохиолдолд хуульчийн зөвшөөрлийг дуусгавар болгоно:

23.1.1.хуульч өөрөө хүсэлт гаргасан;

23.1.2.хуульч нас барсан, эсхүл хуульчийг нас барсанд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

23.1.3.хуульчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан үндэслэлээр хуульчийн зөвшөөрлийг дуусгавар болгох, сэргээх шийдвэрийг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч гаргана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХУУЛЬЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

## **24 дүгээр зүйл.Хуульч нэрийг хэрэглэх**

24.1.Хуульчийн зөвшөөрөл авсан этгээд хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхтэй болно.

24.2.Хуульчийн эрхийг хүчингүй, эсхүл дуусгавар болгосон бол тухайн этгээд хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхгүй болно.

## **25 дугаар зүйл.Хуульчийн тангараг**

25.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуульч "Хуульч би Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг даган мөрдөж, хуульчийн үүргээ шударгаар биелүүлж, ёс зүйг чанд сахиж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, тууштай хамгаалахаа батлан тангаргалъя." гэж тангараг өргөнө.

25.2.Хуульчийн тангараг өргөх ёслолын журмыг Хуульчдын холбооны Зөвлөл батална.

## **26 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл**

26.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь дараахь төрөлтэй байна:

- 26.1.1.шүүгчийн үйл ажиллагаа эрхлэх;
- 26.1.2.прокурорын үйл ажиллагаа эрхлэх;
- 26.1.3.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;
- 26.1.4.нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх;
- 26.1.5.хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх;

26.2.Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4-т заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журмыг холбогдох хуулиар, энэ хуулийн 26.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журмыг энэ хуулиар зохицуулна.

## **27 дугаар зүйл.Хуульчийн нийтлэг эрх**

27.1.Хуульч нь дараахь нийтлэг эрхийг эдэлнэ:

27.1.1.бусдын хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;  
27.1.2.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг бүрдүүлэх, түүнийг сайжруулахыг шаардах;

27.1.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцад аливаа этгээд хууль зөрчсөн нь илэрсэн бол холбогдох арга хэмжээ авахуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

27.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүнийг эрхлэх зөвшөөрөлтэй нь холбогдуулан гаргасан шийдвэртэй танилцах, тэдгээрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

27.1.5.хуулиар хориглоогүй ажил хөдөрмөр, албан тушаал эрхлэх, аливаа үйл ажиллагаанд оролцох;

27.1.6.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө дуусгавар болгох;

27.1.7.Хуульчдын холбооноос эрхлэн хөтөлдөг өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах бүртгэл, баримт бичигтэй танилцах, Хуульчдын холбооны Ажлын албанаас шаардлагатай мэдээлэл авах;

27.1.8.мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор сургалтад хамрагдах;

27.1.9.Хуульчдын холбооны Их хурлын төлөөлөгч, Ерөнхийлөгч, Зөвлөлийн гишүүн, чиг үүргийн хорооны гишүүнд нэр дэвших;

27.1.10.Хуульчдын холбооны үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмын дагуу оролцох, санхүүгийн тайлантай танилцах;

27.1.11.хуульд заасан шаардлага хангасан бол шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн мэргэшлийн болон ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвших;

27.1.12.хууль, Хуульчдын холбооны дүрэмд заасан бусад.

27.2.Хуульч нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй бөгөөд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаар үндэсний болон олон улсын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн хурал, цуглаанд оролцох эрхтэй.

27.3.Хуульч энэ хуулийн 27.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд захирагдана.

## **28 дугаар зүйл.Хуульчийн нийтлэг үүрэг**

28.1.Хуульч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

28.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон Хуульчийн ёс зүйн дүрэмд захирагдах;

28.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх, шударга ёсыг эрхэмлэн мэргэжлийн нэр хүндийг сахих;

28.1.3.хуульчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, олон нийтэд хүндлэл, итгэл хүлээхүйц байдлаар биеэ авч явах;

28.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг гагцхүү өөрөө буюу биечлэн эрхлэх;

28.1.5.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг шударгаар эрхлэх;

28.1.6.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хууль бус үйлдэл хийхгүй байх, бусад хуульчдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах;

28.1.7.Хуульчдын холбооноос зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцох;

28.1.8.өөрийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдах, энэ хууль болон Хуульчдын холбооноос баталсан журамд заасан хугацаанд тогтоосон багц цагийн сургалтад тогтмол хамрагдах;

28.1.9.бусдын хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах, хууль бус аливаа нөлөөлөлд автахгүй байх;

28.1.10.бусдын хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

28.1.11.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцад аливаа этгээд хууль зөрчсөн нь илэрсэн бол холбогдох арга хэмжээ авахуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

28.1.12.Хуульчдын холбооны гишүүн байж, гишүүний хураамж төлөх;

28.1.13.нийтийн ашиг сонирхолд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;

28.1.14.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах

28.1.15.хууль, Хуульчдын холбооны дүрэмд заасан бусад үүрэг.

## **29 дүгээр зүйл.Хуульчид хориглох зүйл**

29.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараахь үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

29.1.1.Хууль, хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгах;

29.1.2.хуульчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх гэмт хэрэг, зөрчил үйлдэх;

29.1.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бус аргаар эрхлэх;

29.1.4.төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хуульчдийн мэргэжлийн үйл ажиллагаа, тэдгээрээс шийдвэр гаргах үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх;

28.1.5.хуульчийн мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар задруулах, уг мэдээллийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд ашиглах;

28.1.6.хууль тогтоомж болон үйл баримтын талаар худал мэдээлэл өгөх;

28.1.7.хувийн ашиг сонирхлын үүднээс өөрийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хамаарахгүй хэрэг маргааны материал, баримт бичиг, мэдээ, мэдээлэлтэй танилцах, тэдгээрийг эрж хайх, хорих байгууллагад нэвтрэх, сэжигтэн, яллагдагч, хоригдолтой уулзах;

29.1.8.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх;

29.1.9.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад худал мэдүүлэг, хуурамч баримт сэлт, мэдээ, мэдээлэл гаргаж өгөх, тэдгээрийг мэдсээр байж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах, бусдаар худал тайлбар, мэдүүлэг нотлох баримт, баримт сэлт, мэдээ, мэдээлэл гаргаж өгөхийг зөвлөх, шаардах, уг үйлдэлд нь зөвшөөрөл олгох, туслах, дэмжих, зохион байгуулах;

29.1.10.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд нь хамаарах этгээдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, эзэмших;

29.1.11.хуульд заасан эрх хэмжээгээ хэтрүүлэх, хувийн ашиг сонирхлын тулд урвуулан ашиглах, бусдыг аливаа хэлбэр, үндэслэлээр ялгаварлан гадуурхах, бусдад хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах;

29.1.12.шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн аливаа арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

29.1.13.хуульд заасан эрх хэмжээгээ шашны, эсхүл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаанд ашиглах;

29.1.14.хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил бүхий, эсхүл татгалзан гарах үндэслэл бүхий нөхцөл байдалд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;

29.1.15.бусдын хууль бус хүсэлт, үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлэх, биелүүлэхээр зөвшөөрөх;

29.1.16.шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй эрүүгийн хэргийн яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугийн талаар өөрийн байр сууриа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгөх;

29.1.17.хэрэг, маргааны талаар худал ташаа мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараах, мэдээлэх;

29.1.18.хууль, Хуульчийн ёс зүйн дүрэмд заасан бусад.

29.2.Энэ хуульд зааснаас бусад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хууль, хуульчийн ёс зүйн дүрмээр тогтооно.

### **30 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм**

30.1.Хуульч хууль тогтоомжид нийцсэн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, нэр хүнд, ёс зүйн нийтлэг стандарттай байна.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан нэгдсэн стандартыг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм /цаашид "Хуульчийн ёс зүйн дүрэм" гэх/-ээр тогтооно.

### **31 дүгээр зүйл.Мэргэшсэн хуульч**

31.1.Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг тодорхой төрлийн хэрэг, маргаан, салбар, эрх зүйн чиглэлээр дагнан, эсхүл голчлон эрхлэлдэг бол мэргэшсэн хуульч гэх нэршлийг хэрэглэх эрхтэй.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасан нэршлийг хэрэглэхэд дараахь шаардлагын аль нэгийг хангасан байна:

31.2.1.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 8 жил, түүнээс хугацаагаар эрхэлсэн, нийт оролцсон хэрэг, маргааны 50, түүнээс дээш хувь нь мэргэшсэн чиглэлд хамаарах асуудлаар хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн;

31.2.2.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 5 жил, түүнээс дээш хугацаагаар эрхэлсэн, мэргэшсэн чиглэлээр хууль зүйн боловсролын, эсхүл шинжлэх ухааны докторын зэрэг авсан;

31.2.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 5 жил, түүнээс дээш хугацаагаар эрхэлсэн, мэргэшсэн чиглэлд хамаарах сэдвээр Хуульчдын холбооноос магадлан итгэмжилсэн хууль зүйн сургуульд 3 жил, түүнээс дээш хугацаагаар үндсэн багшаар, 4 жил, түүнээс дээш хугацаагаар гэрээт багшаар ажилласан;

31.2.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 5 жил, түүнээс дээш хугацаагаар эрхэлсэн, энэ хуулийн 35.1-д заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдсан;

31.2.5.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 8 жил, түүнээс дээш хугацаагаар эрхэлсэн, мэргэшсэн чиглэлээр дагнан үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн гишүүн хуульчаар 5 жил, түүнээс дээш хугацаагаар ажилласан.

31.3.Мэргэшсэн хуульч нь Хуульчдын холбооноос баталсан мэргэшсэн чиглэлд хамаарах сэдвээр тогтмол сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлж байх үүрэгтэй.

31.4.Мэргэшсэн хуульч гэх нэршлийг хэрэглэх эрхийг Хуульчдын холбоо олгох бөгөөд мэргэшсэн хуульчийг бүртгэх журам болон мэргэших чиглэлийн жагсаалтыг Хуульчдын холбоо батална.

### **32 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа**

32.1.Хуульч нийгмийн эмзэг бүлгийн хууль ёсны ашиг сонирхол болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үйл ажиллагаа эрхлэх үүрэгтэй.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа нь дараахь хэлбэртэй байна:

32.2.1.хуульд заасны дагуу нийгмийн зорилтот бүлэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

32.2.2.сайн дурын үндсэн дээр нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлэх;

32.2.3.нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилгод хамаарах асуудлаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

32.2.4.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл давхардал, хийдэл, зөрчил бүхий хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах, боловсронгуй болгуулах асуудлаар эрх бүхий этгээдэд хандан шийдвэрлүүлэх, эсхүл тэдгээрийг шинээр боловсруулах үйл ажиллагаанд оролцох;

32.2.5.эрх зүйн бүх нийтийн боловсролыг дэмжих зорилгоор олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа эрхлэх;

32.3.Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх цаг, цагийг тооцох журмыг Хуульчдын холбооны Зөвлөл батална.

32.4.Хуульч энэ хуульд заасан нийтэд тустай хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор энэ хуулийн 32.2.2, 32.2.3, 32.2.4-т заасан асуудлаар өөрийн нэрийн өмнөөс төрийн байгууллага, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.5.Хуульчдын холбоо нь хуульчдаас нийтэд тустай хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх үүсэл санаачлагыг дэмжих, тэдгээрийг уялдуулан зохион байгуулах, уул үйл ажиллагаанд нийт хуульчдын оролцоог хангах үүрэгтэй.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН СУРГАЛТ**

### **33 дугаар зүйл.Хуульчийн сургалтын зорилго, хэлбэр**

33.1.Хуульчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Хуульчдын холбоо хуульчийн сургалтыг тогтмол зохион байгуулна.

33.2.Хуульчийн сургалт нь үргэлжилсэн болон мэргэшүүлэх хэлбэртэй байна.

33.3.Сургалтыг багц цагаар тооцох бөгөөд нэг багц цагт ногдох сургалтын хичээлийн цаг, түүнийг хангах журмыг сургалтын асуудал хариуцсан хороо тогтооно.

33.4.Сургалт зохион байгуулахтай холбогдсон харилцааг Хуульчдын холбооноос баталсан журмаар зохицуулна.

#### **34 дүгээр зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалт**

34.1.Хуульчийн үргэжилсэн сургалтын агуулга нь шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэр мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэх, хуульчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.

34.2.Хуульчийн үргэлжилсэн сургалтыг тогтоосон хуваарь, хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулах бөгөөд тухайн жилд явуулах сургалтын хөтөлбөр, хуваарийг Хуульчдын холбооны сургалтын асуудал хариуцсан хороо улирал бүр гаргаж хуульчдад мэдээлнэ.

34.3.Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 5 хүртэлх жилийн хугацаанд эрхэлж байгаа бол үргэлжилсэн сургалтын хүрээнд нэг жилд дөрвөөс доошгүй багц цагийн, 5-аас дээш 10 жил хүртэл хугацаагаар эрхэлж байгаа бол гурваас доошгүй багц цагийн, 10-аас дээш жилийн хугацаагаар эрхэлж байгаа бол хоёроос доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байна.

#### **34.4.Хуульчийн үргэлжилсэн сургалтыг Хуульчдын холбоо зохион байгуулна.**

#### **35 дугаар зүйл.Хуульчийн мэргэшүүлэх сургалт**

35.1.Хуульчийн мэргэшүүлэх сургалтын агуулга нь хуульч эрх зүйн салбарын тодорхой чиглэлээр нарийн мэдлэгтэй болох, уг чиглэлээр мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

35.2.Хуульчийн мэргэшүүлэх сургалтыг хөтөлбөр, хуваарийг энэ хуулийн 34.2-т заасны дагуу гаргаж хуульчдад мэдээлнэ.

35.3.Хуульчийн мэргэшүүлэх сургалт нь 30-аас багагүй багц цаг байна.

35.4.Мэргэшүүлэх сургалтын багц цагийн хэмжээг тухайн сургалтын хөтөлбөр, агуулгад тохируулан энэ хуулийн 35.3-т заасныг баримтлан сургалтын асуудал хариуцсан хороо тогтооно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ**

### **36 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны хэлбэр**

36.1.Энэ хуулийн 36.2-т заасан үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд, тогтмол эрхэлж байгаа болон төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж байгаа хуульчийг хуулийн зөвлөх гэнэ.

36.2.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь дараахь хэлбэртэй байна:

36.2.1.хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх;

36.2.2.хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах;

36.2.3.хууль зүйн асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах;

36.2.4.иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас бусад харилцаанд төрийн болон төрийн бус байгууллагад төлөөлөх;

36.2.5.нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах.

36.3.Хуульчдын холбоо хуулийн зөвлөхийн нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

### **37 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн эрх**

37.1.Хуульд өөрөөр заагүй бол хуулийн зөвлөх нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь эрх эдэлнэ:

37.1.1.нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх, эсхүл хэрэг, маргаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт сэлт цуглуулах;

37.1.2.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төлөөлөх;

37.1.3.үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломж, нөхцөлөөр хангагдах;

37.1.4.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн оролцсон ажиллагааны бусад оролцогчдод асуулт тавьж, хариулт авах;

37.1.5.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад цугларсан баримт сэлт, нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, хуульд өөрөөр заагаагүй бол шаардлагатай материалыг өөрийн зардлаар хуулбарлан авах;

37.1.6.шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, түүнийгээ хэргийн материалд тусгуулах;

37.1.7.шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах, гарсан дүгнэлттэй танилцах;

37.1.8.хуульд заасан үндэслэл байвал хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

37.1.9.захиргааны байгууллага, албан тушаалтан, шүүгч, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

37.1.10.шаардлагатай баримт материалыг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор дуу, зураг, дүрс, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах;

37.1.11.тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, иргэнээс өөрсдийг нь зөвшөөрснөөр, эсхүл гэрээний үндсэн дээр зөвлөгөө авах, тодорхойлолт, дүгнэлт гаргуулан авах;

37.1.12.үйлчлүүлэгч болон бусад этгээдийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;

37.1.13.өөрийн үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны төлөө үндэслэл бүхий хөлс авах, өөрийн гаргасан зардлыг нөхөн төлүүлэх.

37.2.Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болон хөдөлмөрийн гэрээний дагуу чиг үүргээ хэрэгжүүлэх хуулийн зөвлөхийн бусад эрхийг холбогдох хуулиар тогтооно.

### **38 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн үүрэг**

38.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн зөвлөх хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь үүрэг хүлээнэ:

38.1.1.үйлчлүүлэгчид хэрэг, маргаанд хамаарах хууль, эрх зүйн тогтолцооны талаар болон тэдгээрийн хууль ёсны эрх, үүргийн талаар зөвлөгөө өгөх;

38.1.2.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгсэл ашиглан шударгаар, тууштай хамгаалах;

38.1.3.хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах;

38.1.4.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн эсэргүүцэл, шаардлагыг үндэслэлтэй тайлбарлах;

38.1.5.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо холбогдох хуульд заасан журмыг дагаж мөрдөх;

38.1.6.үйлчлүүлэгчийн хүсэл зориг, ашиг сонирхол, шийдвэрийг хүндэтгэх;

38.1.7.үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааны агуулга, түүний хүрээнд явуулж буй үйл ажиллагааны хууль зүйн үр дагавар, хууль тогтоомжийн агуулгыг тайлбарлах;

38.1.8.үйлчлүүлэгчийн зөвшөөрөл шаардлагатай аливаа үйл ажиллагааны талаар түүнд мэдэгдэх;

38.1.9.хууль зүйн мэргэжлийн туслалцааны зорилгод хүрэх арга замын талаар үйлчлүүлэгч, ажил олгогчтой зөвлөлдөх;

38.1.10.шаардлагатай тохиолдолд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомж болон ёс зүйн дүрмээр хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн талаар үйлчлүүлэгч, ажил олгогчид тайлбарлах;

38.1.11.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;

38.1.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

### **39 дүгээр зүйл.Хуулийн зөвлөхөд хориглох зүйл**

39.1.Хуулийн зөвлөхөд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараахь зүйлийг хориглоно:

39.1.1.өөрийн үзэл бодлыг үйлчлүүлэгчид тулгах;

39.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн үйл ажиллагааны нууцыг задруулах, нийтэд мэдээлэх;

39.1.3.мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх, шашны зан үйл ашиглах, үйлчлүүлэгчийг төөрөгдүүлэх, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхээс өмнө мөнгө, бэлэг, аливаа шан харамж авах;

39.1.4.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үнэн бодит байдлыг санаатайгаар нуун дарагдуулах;

39.1.5.хуулийг зориуд буруу хэрэглэх, эсхүл худал, эсхүл үндэслэлгүй, эсхүл хэрэг, маргааны материалд авагдаагүй нотлох баримт, баримт сэлтэд үндэслэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;

39.1.6.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хүсэл зоригын эсрэг байр суурь илэрхийлэх, эсхүл аливаа үйлдэл хийх;

39.1.7.хэрэг, маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээд, эсхүл хэрэг, маргааны оролцогчийг ашиглан өөрийн үйлчилгээг бусдад тулгах, үйлчлүүлэгч олж өгсний төлөө бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах;

39.1.8.өөр хуулийн зөвлөхөөр төлөөлүүлж байгаа өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий хэрэг, маргааны талаас шан харамж авах, тэдгээртэй түүний төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр уулзах;

39.1.9.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатайгаар саад учруулах;

39.1.10.хэрэг, маргааны нөгөө талын нотлох баримт, хэрэгт ач холбогдол бүхий бусад баримт сэлт, мэдээ, мэдээлэл олж авахад нь саад учруулах, тэдгээрт хууль бусаар өөрчлөлт оруулах, устгах, нуун дарагдуулах, бусдыг уг үйл ажиллагаанд хатгах, туслах;

39.1.11.хууль, хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд заасан бусад.

#### **40 дүгээр зүйл.Гадаад улсын хуулийн зөвлөх Монгол Улсад хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх**

40.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хуульчийн шалгалтад тэнцэж, энэ хуульд заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн төрийн болон албаны нууцтай холбоотойгоос бусад асуудлаар хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж болно.

40.2.Гадаадын аль нэг улсад хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий гадаад улсын болон Монгол Улсын харьяат өмгөөлөгч зөвхөн эрх олгосон орны хууль тогтоомж болон олон улсын эрх зүйд хамаарах асуудлаар хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлнэ.

40.3.Энэ хуулийн 40.2-т заасан хуулийн зөвлөх хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу Хуульчдын холбоонд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болох бөгөөд хуульд тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд энэ хуульд заасан ерөнхий нөхцөл, шаардлагын дагуу хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлнэ.

40.4.Хуулийн зөвлөх гадаад улсын иргэний харьяалалтай болсон нь бусад хууль, энэ хуулийн 40.1-д зааснаас бусад байдлаар түүний хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

#### **41 дүгээр зүйл.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр**

41.1.Хуулийн зөвлөх хуулийн зөвлөхийн үйл ажиллагааг ганцаарчлан, гэрээгээр хамтарч, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр, эсхүл хуулийн этгээд байгуулан эрхэлж болно.

41.2.Ганцаарчлан, эсхүл гэрээгээр хамтарч хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн зөвлөх болон хуулийн зөвлөх үйл ажиллагаа дагнан эрхэлдэг хуулийн этгээд нь ажлын байр, банкинд харилцах данстай байна.

## **42 дугаар зүйл.Хуулийн зөвлөх үйл ажиллагаа дагнан эрхлэх хуулийн этгээд**

42.1.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа дагнан эрхлэх хуулийн этгээд /цаашид “Хуулийн зөвлөхийн хуулийн этгээд” гэх/-ийн хэлбэр нь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байна.

42.2.Хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн оноосон нэрийн урд “хуулийн зөвлөхийн” гэсэн үгийг хэрэглэнэ.

42.3.Хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 14 хоногийн дотор хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, түүнд ажиллах хуулийн зөвлөхийн нэрсийг Хуульчдын холбоонд бүртгүүлэх бөгөөд уг бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрт Хуульчдын холбоонд бичгээр мэдэгдэнэ.

42.4.Хуулийн зөвлөхийн хуулийн этгээд нь хуулийн зөвлөхийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

42.5.Хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн гишүүн, удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд нь хуулийн зөвлөх, өмгөөлөгч байна.

42.6.Хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээд нь хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээдтэй хамтарч ашиг хуваах байдлаар үйл ажиллагаа эрхэлж болохгүй.

42.7.Хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн энэ хуульд заагаагүй бусад харилцааг Нөхөрлөлийн тухай хуулиар зохицуулна.

## **43 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчилтэй хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглох**

43.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн зөвлөхөд дараахь тохиолдолд үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хориглоно:

43.1.1.хэрэг, маргааны үр дүнгийн талаар үйлчлүүлэгчээс өөр ашиг сонирхолтой;

43.1.2.хэрэг, маргааныг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд хуулийн зөвлөхөөс бусад оролцогчийн хувиар оролцож байсан, эсхүл үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хөндсөн маргаан бүхий шийдвэрийг гаргах эрх бүхий ажил, албан тушаал эрхэлж байсан;

43.1.3.хэрэг, маргааныг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд оролцсон, эсхүл оролцож байгаа этгээдтэй төрөл садангийн, эсхүл гэр бүлийн харилцаатай;

43.1.4.хэрэг, маргааны үр дүнийн талаар үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий өөр этгээдэд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж байгаа;

43.1.5.хэрэг, маргааныг хянан шалгаж, эсхүл шийдвэрлэж байгаа байгууллагад, эсхүл түүний үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий ажил, албан тушаал эрхэлж байсан бөгөөд түүнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрөөгүй;

43.1.6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.1-д заасан нөхцөл байдал үүссэн;

43.1.7.оролцож байгаа хэрэг, маргааны нөгөө тал буюу хэрэг, маргааны үр дүнгийн талаар эсрэг ашиг сонирхолтой этгээд, эсхүл түүний төлөөлөгч, хуулийн зөвлөхтэй өөр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг тал болж оролцож байгаа;

43.1.8.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчтой хамаарал бүхий этгээдийн харилцаатай;

43.1.9.тухайн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцож байсан, эсхүл гэрчээр оролцох хангалттай үндэслэлтэй;

43.1.10.урьд өмнө хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлсэн этгээд болон гуравдагч этгээдийн өмнө хууль, аливаа хэлцэлээр хүлээсэн үүрэг нь тухайн үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааг шударгаар үзүүлэхэд харшлах бусад тохиолдол.

43.2.Хуулийн зөвлөхийн нэг хуулийн этгээдэд харьяалагдах, эсхүл ашгаа хуваах байдлаар хамтран ажилладаг хуулийн зөвлөхүүд харилцан эсрэг ашиг сонирхол бүхий хэрэг, маргааны талуудад нэгэн зэрэг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хориглоно.

43.3.Хуулийн зөвлөх энэ хуулийн 43.1-д заасан нөхцөл байдлын талаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж эхлэхээс өмнө мэдсэн бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхээс татгалзах, түүнийг үзүүлэх явцад олж мэдсэн тохиолдолд хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох үүрэгтэй.

**44 дүгээр зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох**

44.1.Хуулийн зөвлөх хуульд заасан үндэслэлээр үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааг үргэлжлүүлэн үзүүлэх боломжгүй болсон бол хууль зүйн мэргэжлийн туслалцааг гэрээнд заасан хугацаанаас өмнө дуусгавар болгоно.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан тохиолдол үүссэн, эсхүл үүсэх нь тодорхой болсон тохиолдолд хуулийн зөвлөх үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үргэлжлүүлэн үзүүлэх хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийг үйлчлүүлэгчид санал болгож болно.

44.3.Энэ хуулийн 44.1-д заасан тохиолдолд хуулийн зөвлөх хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл болон үйлчлүүлэгчид үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцаатай холбоотой баримт бичиг, эд зүйл, үйлчлүүлэгчид буцаан төлбөл зохих хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөлсийг хүлээлгэн өгөх зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

#### **45 дугаар зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ**

45.1.Хуулийн зөвлөх хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлчлүүлэгчид, эсхүл түүний сонгосон этгээдтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх тухай гэрээг бичгээр байгуулна.

45.2.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээнд дараахь зүйлийг тусгасан байна:

45.2.1.хуулийн зөвлөхийн нэр, хаяг;

45.2.2.хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн нэр, хаяг;

45.2.3.хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны хэлбэр, түүний агуулга;

45.2.4.хууль зүйн мэргэжлийн туслалцааны төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх нөхцөл, дансны дугаар;

45.2.5.хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад хуулийн зөвлөхөөс гарах зардлыг нөхөн төлөх нөхцөл;

45.2.6.хуулийн зөвлөхийн хариуцлагын хэлбэр болон хэмжээ;

45.2.7.гэрээг цуцлах нөхцөл.

45.3.Энэ хуулийн 45.2-т зааснаас бусад нөхцөлийг талууд харилцан тохиролцож тогтоож болно.

45.4.Хуулийн зөвлөх үйлчлүүлэгчийг итгэмжлэл, хүсэлт, эсхүл Хуульчдын холбооноос олгосон томилолтын үндсэн төлөөлөх бөгөөд хэн боловч хуулийн зөвлөх болон түүний үйлчлүүлэгчээс хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ, түүний хуулбарыг шаардах эрхгүй.

#### **46 дугаар зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөлс**

46.1.Хуулийн зөвлөх хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхдээ үйлчлүүлэгчээс хөлс /цаашид “хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөлс” гэх/ авах бөгөөд хэмжээг хуулийн зөвлөх, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.

46.2.Хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөлсийг тогтооход дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

46.2.1.хэрэг, маргаан, үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврын цар хүрээ, ээдрээ төвөгтэй байдал;

46.2.2.үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврыг биелүүлэхэд зарцуулах хугацаа буюу тухайн хэрэг, маргааны үргэлжлэх хугацаа;

46.2.3.хуулийн зөвлөхийн мэргэшсэн байдал, туршлага, мэргэжлийн ур чадвар;

46.2.4.үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврыг биелүүлсэн байх хугацаа;

46.2.5.тусгай мэдлэг шаардах асуудлаар мэргэжлийн байгууллага, иргэнийг туслалцаа авах шаардлагатай эсэх;

46.2.6.хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөлсийг тогтооход шаардлагатай бусад.

46.3.Хуулийн зөвлөх болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон тохиолдолд хөрөнгийн талаархи хэрэг, маргаанд үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дүнгээс хамаарсан хөлсийг нөхцөлтэйгээр тохиролцож болно.

#### **47 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн мэргэжлийн хариуцлагын даатгал**

47.1.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээний нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутсаны улмаас хуулийн зөвлөхийн үйл ажиллагаанд алдаа гаргаж, үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор хуулийн зөвлөх мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

47.2.Хуулийн зөвлөхийн мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний хэмжээ буюу даатгалын тохиолдолд олгох нөхөн төлбөрийн доод хэмжээг Хуульчдын холбооны саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо тогтоох бөгөөд хуулийн зөвлөхийг хариуцлагын даатгалд даатгуулах ажлыг Хуульчдын холбоо зохион байгуулна.

#### **48 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууц**

48.1.Хуулийн зөвлөхөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцад хамаарна.

48.2.Үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх болон бусад этгээдээс хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсч хуулийн зөвлөхөд хандах явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан хуулийн зөвлөхийг гэрчээр байцаах, тайлбар авахыг хориглоно.

48.3.Хуулийн зөвлөх хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцыг үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задлах, үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харшлах байдлаар, эсхүл хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд ашиглахыг хориглоно.

48.4.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцыг хугацаагүй хадгална.

48.5.Энэ хуулийн 48.2, 48.3-т заасан нь хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэх явцад хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцыг олж мэдсэн хуулийн зөвлөхийн туслах, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн бусад ажилтанд нэгэн адил хамаарна.

48.6.Хуулийн зөвлөх болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй бодит аюулыг зайлуулах, эсхүл хуулийн зөвлөхөд холбогдуулан үүсгэсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийн зөвлөх өөрийн тайлбар, мэдүүлэг, бусад нөхцөл байдлыг нотолбол зохих хэмжээнд хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр задруулж болно.

48.7.Энэ зүйлд заасан үйлчлүүлэгчийн нууцыг хамгаалах тухай зохицуулалт нь Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад мэдээлэх үүрийг хэрэгжүүлэхэд хамаарахгүй.

#### **49 дүгээр зүйл.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны баталгаа**

49.1.Хуульд заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, дуусгавар болгосноос бусад тохиолдолд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан хуулийн зөвлөхийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх болон үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглоно.

49.2.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч хуулийн зөвлөх хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлэх, саад учруулах, баталгаа шаардах, заналхийлэх буюу бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

49.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн зөвлөхийн үйл ажиллагаатай нь холбогдуулан хуулийн зөвлөх, түүний туслах, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн ажилтны яриаг чагнах, албан байр болон орон байр, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, мөрдөн мөшгих, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг гаргуулан авахыг хориглоно.

### **50 дугаар зүйл.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны талаархи зар сурталчилгаа**

50.1.Хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээд өөрийн үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааны талаар зар, сурталчилгаа явуулах эрхтэй.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан зар сурталчилгаа нь хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн талаар ерөнхий мэдээлэл, ажлын туршлага, боловсролын байдал болон үзүүлэх хууль зүйн мэргэжлийн туслалцааны талаархи мэдээллийг агуулгасан байх бөгөөд доор дурдсан агуулгатай байхыг хориглоно:

50.2.1.хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дүнгийн талаар тодорхой амлалт өгсөн;

50.2.2.тухайн хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн үйлчилгээг авахыг тулган шаардсан;

50.2.3.бусад хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан;

50.2.4.өөрийн болон бусад хуулийн зөвлөх, хуулийн зөвлөхийн хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаар үнэлгээ, дүгнэлт өгсөн;

50.2.5.хуулийн зөвлөхийн үйл ажиллагаатай холбоотой хуурамч, эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл агуулсан;

50.2.6.энэ хууль болон ёс зүйн дүрэмд нийцээгүй бусад.

### **ДОЛДУГААР ЗҮЙЛ ХУУЛЬЧДЫН ХОЛБОО, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

#### **51 дүгээр зүйл.Хуульчдын холбоо**

51.1.Хуульчдын холбоо нь хуульчийг сонгон шалгаруулах, хуульчийн мэдлэг, ур чадварт тавигдах нэгдсэн шаардлагыг тодорхойлох, хуульчийн эрх ашгийг хамгаалах, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

51.2.Хуульчдын холбооны үйл ажиллагааг дүрмээр зохицуулах бөгөөд дүрмийг Хуульчдын холбооны Их Хурал батална.

51.3.Хуульч бүр Хуульчдын холбооны гишүүн байна.

## **52 дугаар зүйл.Хуульчдын холбооны бүрэн эрх**

52.1.Хуульчдын холбоо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

52.1.1.хуульчийн шалгалт зохион байгуулах;

52.1.2.хуульчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох;

52.1.3.хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, багц цагийг тооцож, бүртгэх;

52.1.4.хуульчийн ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийх, хуульчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх, зөвлөмж гаргах;

52.1.5.хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

52.1.6.Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэг гишүүнийг нэр дэвшүүлэх, эгүүлэн татах;

52.1.8.шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн ёс зүйн асуудал хариуцсан хорооны гишүүнд нэр дэвшүүлэх;

52.1.9.Хуульчийн ёс зүйн дүрэм батлах, сахиулах;

52.1.10.хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх;

52.1.11.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх;

52.1.12.хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх;

52.1.13.мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлыг зохион байгуулах.

## **53 дугаар зүйл.Хуульчдын их хурал**

53.1.Хуульчдын өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь Хуульчдын их хурал байна.

53.2.Хуульчдын их хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

53.2.1.Хуульчдын холбооны дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

53.2.2.Хуульчийн ёс зүйн дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

53.2.3.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

53.2.4.Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;

53.2.5.Хуульчдын холбооны Зөвлөлийн болон Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж өгөх;

53.2.6.Хяналтын зөвлөл, Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнийг сонгох, чөлөөлөх;

53.2.7.Хуульчдын холбооны гишүүний хураамжийн хэмжээг тогтоох;

53.2.8.Хуульчдын холбооны бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

53.2.8.Хуульчдын холбооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

53.3.Хуульчдын их хурлын ээлжит хуралдаан 3 жилд нэг удаа хуралдах бөгөөд Хуульчдын их хурал хуралдаан даргалагчаа сонгож, хуралдааны дэгээ тогтооно.

53.4.Хуульчдын их хурал хуульчдын төлөөлөгчдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

53.5.Хуульчдын их хуралд оролцох хуульчдын төлөөлөгчдийг сонгох журмыг Хуульчдын холбооны дүрмээр тогтооно.

53.6.Хуульчдын их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хуралдаан эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

53.7.Хуульчдын их хурал энэ хуулийн 53.2.1, 53.2.2, 53.2.7-д заасан асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн дийлэнх олонхийн саналаар, бусад асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар тус тус шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.

53.8.Хуульчдын их хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар Хуульчдын их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа бичгээр битүүмжлэн ирүүлж болно.

53.9.Энэ хуулийн 53.9-д заасны дагуу ирсэн саналыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгээр зохицуулна.

53.10.Хуульчдын холбооны гишүүн Их Хуралд төлөөлөгчөөр сонгогдсон эсэхээс үл хамааран өөрийн хүсэлтээр Их Хуралд саналын эрхгүйгээр оролцож болно.

#### **54 дүгээр зүйл.Хуульчдын холбооны Зөвлөл**

54.1.Хуульчдын холбооны Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь Хуульчдын холбооны үйл ажиллагааг бодлогын удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага байна.

54.2.Зөвлөл нь 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуулийн зөвлөхүүдийн төлөөлөл тус бүр хоёр, энэ хуулийн 59.2-т заасан чиг үүргийн хороодийн төлөөлөл тус бүр нэг байна.

54.3.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна. Хуульч хоёроос дээш удаа Зөвлөлийн гишүүнээр сонгогдож болохгүй бөгөөднэг Их Хурлаас сонгогдсон Зөвлөлийн гишүүдийн 60-иас илүү хувийг улируулан сонгохгүй.

54.4.Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн саналаар Зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгож, Их Хурлаар батламжилна. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь бусад гишүүдийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.

54.5.Зөвлөлийн гишүүн Мэргэжлийн хариуцлагын хорооны болон Хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллахгүй.

54.6.Зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

54.7.Зөвлөл цаг үеийн асуудлаар зөвлөлийн гишүүдийн санал болон Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн шийдвэрээр хуралдаж болно.

54.8.Энэ хуулийн 54.2-т заасан Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр Зөвлөлийн хурал хүчинтэй болох бөгөөд хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр батлагдана.

54.9.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн санал тэнцсэнээс бусад тохиолдолд саналын эрхгүй байна.

54.10.Зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

54.10.1.Хуульчдын холбооны Их Хурлаас баталсан Хуульчдын холбооны бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцүүлэн Хуульчдын холбооны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

54.10.2.Хуульчийн ёс зүйн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэж Хуульчдын их хуралд оруулах, Хуульчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх;

54.10.3.Хуульчдын холбооны чиг үүргийн хороодын үйл ажиллагааг удирдах, түүнд хяналт тавих;

54.10.4.энэ хуульд заасан бусад дүрэм, журмыг батлах;

54.10.5.Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад Чиг үүргийн хороог байгуулж, даргыг нь хоёр жилийн хугацаатайгаар томилох;

54.10.6.Чиг үүргийн хорооноос бусад хороог батламжлах;

54.10.7.Хуульчдын холбооны Ажлын алба /цаашид "Ажлын алба" гэх/-ын бүтэц, орон тоог батлах, ажилтны цалингийн хэмжээг тогтоох;

54.10.8.Хуульчдын холбооны төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах;

54.10.9.Хуульчдын холбооны орон нутаг дахь салбар, нэгжийг байгуулах, татан буулгах;

54.10.10.Хуульчдын холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар хуульчдаас гаргасан өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх, шаардлагатай бол Хуульчдын их хурлаар хэлэлцүүлэх;

54.10.11.гишүүний хураамжийн хэмжээ, түүнээс чөлөөлөх, хөнгөлөх журмыг батлах;

54.10.12.энэ хууль болон Хуульчдын холбооны дүрэм, Хуульчдын холбооноос баталсан журмын биелэлтэд хяналт тавих;

54.11.Зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

54.12.Зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулж, шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

*Тайлбар: -Энэ хуулийн 54.4-т заасан "хүндэтгэн үзэх шалтгаан" гэж энэ хуулийн 19.1, 21.1, 22.2, 22.1-т заасан үндэслэл болон шүүгч, прокурор, өмгөөлөгч хуульд заасан үндэслэл, журмын дагуу мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаас чөлөөлөгдсөн байхыг ойлгоно.*

## **55 дугаар зүйл.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч**

55.1.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь хуульчийн хувьд манлайлагч, хуульчдын нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, хуульчдыг байр суурь, бодлогын хувьд илэрхийлэгч байна.

55.2.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

55.3.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.3.1.Хуульчдын холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

55.3.2.Зөвлөлийн хуралдааныг даргалах;

55.3.3.Зөвлөлтэй зөвшилцөн Хуульчдын их хурлыг зарлан хуралдуулах;

55.3.4.Хуульчдын холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах;

55.3.5.Хуульчдын холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

55.3.6.Хуульчдын холбооны Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн талаархи саналыг Зөвлөлд танилцуулах;

55.3.7.Ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;

55.3.8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс сонгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгох;

55.3.9.Холбооноос хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх болон цаг үеийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар Хуульчдын холбооны чиг үүргийн хороод, хуульчдын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

55.3.10.энэ хуулиар болон Хуульчдын холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

55.4.Хуульчдын холбооны Ажлын албаны дарга нь Ажлын албыг удирдана.

## **56 дугаар зүйл.Ажлын алба**

56.1.Ажлын алба нь Хуульчдын холбоо, түүний хороодын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

56.2.Ажлын албаны ажилтан нь хуульчийн зөвшөөрөлтэй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

56.3.Ажлын алба нь үйл ажиллагаандаа энэ хууль, Хуульчдын холбооны дүрэм болон Их Хурал, Ерөнхийлөгчийн шийдвэрийг дагаж мөрдөх бөгөөд түүний чиг үүргийг Хуульчдын холбооны дүрмээр тогтооно.

## **57 дугаар зүйл.Хяналтын зөвлөл**

57.1.Хяналтын зөвлөл нь Хуульчдын холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

57.2.Хяналтын зөвлөл нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуулийн зөвлөх, бусад хуульчдын төлөөллөөс бүрдсэн 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.

57.3.Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх журмыг Хуульчдын холбооны дүрмээр зохицуулна.

57.4.Хяналтын зөвлөлийн гишүүн Мэргэжлийн хариуцлагын болон чиг үүргийн хорооны гишүүнээр ажиллахгүй.

## **58 дугаар зүйл.Хуульчдын холбооны санхүүжилт**

58.1.Хуульчдын холбооны санхүүжилт нь Хуульчийн шалгалтын болон хуульчийн нэгдсэн бүртгэлийн хураамж, гишүүний хураамж, сургалтын төлбөр, хэвлэн нийтлэлийн орлого, хандив, тусламжаас бүрдэнэ.

58.2.Хуульчдын холбооны санхүүгийн тайлан нээлттэй байх ба санхүүгийн үйл ажиллагаанд 2 жил тутам аудит хийлгэж, олон нийтэд мэдээлнэ.

## **59 дүгээр зүйл.Хуульчдын холбооны хороод**

59.1.Холбоо нь чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Зөвлөл хорооны үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөхгүй.

59.2.Энэ хуулиар Хуульчдын холбооны тодорхой чиг үүргийг тусгайлан хариуцаж ажиллахаар заасан хороодыг "Чиг үүргийн хороо" гэж нэрлэх бөгөөд Чиг үүргийн хороо үйл ажиллагаагаа Зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

59.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол чиг үүргийн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуулийн зөвлөх тус бүрийн тэнцүү тооны төлөөлөл орно.

59.4.Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд тэдгээрийг хоёроос дээш удаа улируулан сонгохгүй. Хорооны гишүүдийн 60-иас илүү хувийг улируулан сонгохгүй.

59.5.Чиг үүргийн хороо нь даргатай байх бөгөөд даргыг чөлөөлөх, томилох асуудлыг хорооны гишүүдийн олонхи санал болгосноор Хуульчдын холбооны ЕрөнхийлөгчХуульчдын холбооны Зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.

59.6.Энэ хуулийн 63.1-д зааснаас бусад чиг үүргийн хорооны бүрэлдэхүүнийг Зөвлөл батална.

59.7.Чиг үүргийн хорооны үйл ажиллагаа явуулах хэлбэр нь хорооны хуралдаан байх ба гишүүдийн олонхи оролцсоноор хүчинтэй болно.

59.8.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хорооны даргын саналаар шийдвэрлэнэ.

59.9.Хуульч хоёроос илүүгүй чиг үүргийн хороонд томилогдон ажиллаж болно.

59.10.Чиг үүргийн хорооны энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Хуульчдын холбооны дүрэм, чиг үүргийн хороодын үйл ажиллагаа явуулах нийтлэг журмаар зохицуулна.

59.11.Хуульчид эрх зүйн салбар болон тусгай асуудлаар нэгдэж, сайн дурын хороо байгуулж болно.

59.12.Сайн дурын хороог байгуулах болон үйл ажиллагаа явуулах журмыг Хуульчдын холбооны дүрмээр тогтооно.

59.13.Энэ хуулийн 63.1-д зааснаас бусад чиг үүргийн хороод энэ хууль, Хуульчдын холбооны дүрэмд заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн бол Хуульчдын холбооны Ерөнхийлөгч чиг үүргийн хорооны дарга, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох саналыг Хуульчдын холбооны Зөвлөлд тавьж шийдвэрүүлнэ.

## **60 дугаар зүйл.Хуульчдын холбооны хороодын ажиллах журам**

60.1.Хорооны дарга, гишүүн хорооны хуралдаан, түүний үйл ажиллагаанд тогтмол оролцох үүрэгтэй бөгөөд хорооны шийдвэр болон хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, хорооны шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд өөрийн саналыг тусгайлан тэмдэглүүлэх, өөрийн биеэр хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хэлэлцэх асуудлын талаархи саналаа бичгээр гаргах эрхтэй.

60.2.Хорооны гишүүд хорооны хуралдааны товд багтсан асуудлыг хэлэлцэх, уг асуудлын талаар өөрийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэх, санал гаргах тэгш эрхтэй.

60.3.Хорооны үйл ажиллагаа нь түүний үйл ажиллагааны төлөвлөгөө болон Хуульчдын холбооны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдана.

60.4.Хорооны хурлыг түүний дарга, гишүүдийн олонхийн саналаар, эсхүл цаг үеийн хэрэгцээ, шаардлагаар зарлан хуралдуулах бөгөөд 2 сард нэг удаа заавал хуралдана.

60.5.Хорооны хуралдаанд түүний даргын зөвшөөрснөөр хэлэлцэх асуудалтай холбоотой мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөллийг байлцуулж болно.

60.6.Хороод Хуульчдын холбооны Их Хурал, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тус тусын чиг үүргийн хүрээнд бэлтгэнэ.

60.7.Хороо Хуульчдын холбооны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтнаас хорооны чиг үүргийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэлийг гаргуулах талаар харилцах, чиг үүрэгтээ хамаарах асуудлаар хамтран ажиллана.

60.8.Хорооны хуралдааны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

60.9.Хороо жил бүрийн сүүлийн сарын эхний долоо хоногт багтаан үйл ажиллагааныхаа үр дүнг Хуульчдын холбооны Зөвлөлд тайлагнах бөгөөд Хуульчдын холбооны үйл ажиллагааны жилийн тайланд оруулах асуудлаар санал гаргах эрхтэй.

## **61 дүгээр зүйл.Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо**

61.1.Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны бүрэлдэхүүнд энэ хуулийн 59.3-т зааснаас гадна хуульч эрдэмтэн болон хууль зүйн асуудал төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр нэг байна.

61.2.Хуульчийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

61.2.1.хуульчийн шалгалт зохион байгуулах үүрэг бүхий Шалгалтын комисс байгуулах;

61.2.2.хуульчийн шалгалт зохион байгуулах журам боловсруулж, Зөвлөлөөр батлуулах;

61.2.3.хуульчийн шалгалтын зохион байгуулалт болон даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх;

61.2.4.хуульчийн шалгалтын даалгавар боловсруулах, даалгаврын сан бүрдүүлэх, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэх, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах.

61.2.5.энэ хууль болон Хуульчдын холбооны дүрэм, журамд заасан бусад бүрэн эрх.

## **62 дугаар зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо**

62.1.Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид "Сургалтын хороо" гэх/ дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

62.1.1.хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлох;

62.1.2.мэргэшсэн хуульчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Зөвлөлөөр батлуулах;

62.1.3.хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж, магадлан итгэмжлэх;

62.1.4.сургагч багшийг сонгон шалгаруулж, бүртгэх;

62.1.5.хуульчийн үргэлжилсэн сургалт болон мэргэшүүлэх сургалтын явцад хяналт тавьж, үр дүнгийн талаар дүгнэлт гаргах;

62.1.6.сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж Зөвлөлөөр батлуулах, бүртгэл хөтлөх.

62.2.Сургалтын хороо нь хуульчийн үргэлжилсэн сургалтын чанар, хүртээмж, заавал мэдвэл зохих агуулгад суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх, хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулахад Хуульчдын холбооны бусад хороог оролцуулах ажлыг хариуцна.

### **63 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн хариуцлагын асуудал эрхэлсэн хороо**

63.1.Хуульчдын холбооны Хуульчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хороо /цаашид “Мэргэжлийн хариуцлагын хороо” гэх/ -ны бүрэлдэхүүнд энэ хуулийн 59.3-т зааснаас гадна хуульч эрдэмтэн, иргэний төлөөлөл байна.

63.2.Мэргэжлийн хариуцлагын хороо нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

63.2.1.хуульчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох;

63.2.2.хуульчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хуульчийн ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах;

63.2.3.шүүгчид нэр дэвшигч болон Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнд нэр дэвшигч хуульчийн нэр хүндийн талаар дүгнэлт гаргах;

63.2.4.хуульчид энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

63.2.5.энэ хуульч болон Хуульчдын холбооны дүрэмд заасан бусад.

63.3.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр ажиллах сонирхолтой, энэ хуульч, Хуульчдын холбооны дүрэмд заасан шаардлагыг хангасан хуульч нэрээ дэвшүүлэх хүсэлтийг Хуульчдын холбооны Их Хурал болохоос 60-аас доогүй хоногийн өмнө Хуульчдын холбооны Ажлын албанд ирүүлэх ба Ажлын алба шаардлага хангасан хуульчдын нэрсийн жагсаалтыг Их Хуралд танилцуулан шийдвэрлүүлнэ.

63.4.Энэ хуулийн 63.1-д заасан хуульч эрдэмтэн нь хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийдэг, хуульч зүйн сургуульд тухайн чиглэлээр хичээл заадаг хуульч эрдэмтэн байх бөгөөд иргэний төлөөлөл нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны талаар хувийн ашиг сонирхолгүй, хуульч бус, урьд өмнө хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэн байх бөгөөд түүнийг сонгон шалгаруулах журмыг Мэргэжлийн хариуцлагын хорооны саналыг үндэслэн Зөвлөл батална.

63.5.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнд хуульч, эсхүл иргэн өөрөө нэрээ дэвшүүлнэ.

63.6.Мэргэжлийн хариуцлагын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтэц, орон тоог Мэргэжлийн хариуцлагын хорооны даргын саналыг үндэслэн Удирдах зөвлөл батална.

63.7.Мэргэжлийн хариуцлагын хорооны дарга Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилж, эсхүл чөлөөлнө.

63.8.Мэргэжлийн хариуцлагын хороо нь бие даасан төсөвтэй байх бөгөөд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай байна.

63.9.Мэргэжлийн хариуцлагын хорооны төсвийг Ажлын албаны дарга бие даан захиран зарцуулж, хариуцлага хүлээх бөгөөд төсвийг үндэслэлгүйгээр өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.

63.10.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн, Ажлын албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалтан нь маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх бөгөөд Холбооны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдээс тэдгээрийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг хориглоно.

63.11.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн, Ажлын албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд тавих шаардлагыг Хуульчийн ёс зүйн дүрэмд тусгайлан заана.

#### **64 дүгээр зүйл.Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо**

64.1.Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо /цаашид "Хуульчийн эрхийг хамгаалах хороо" гэх/ нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

64.2.Хуульчийн эрхийг хамгаалах хороо нь энэ хуулийн 64.1-д заасан чиг үүргээ өөрийн санаачилгаар болон Зөвлөлийн даалгавар, хуульчийн хүсэлтээр хэрэгжүүлнэ.

64.3.Хуульчийн эрхийг хамгаалах хороо хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсөн асуудлаар дүгнэлт, хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, зөрчсөн асуудлыг шийдвэрлүүлэхээр санал гаргана.

64.4.Хуульчийн эрхийг хамгаалах хороо нь шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлтэй, прокурорын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн асуудлаар Улсын ерөнхий прокурорын газартай, өмгөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн асуудлаар Монголын Өмгөөлөгчдийн холбоотой, нотариатчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Монголын Нотариатчдын танхимтай хамтран комисс байгуулж болно.

#### **65 дугаар зүйл.Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудлыг эрхэлсэн хороо**

65.1.Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хороо /цаашид "Магадлан итгэмжлэлийн хороо" гэх/ нь магадлан итгэмжлэх комиссын дүрэм, хууль зүйн

сургуульд тавих нэгдсэн шаардлага, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх журмыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

65.2.Магадлан итгэмжлэлийн хорооний бүрэлдэхүүнд энэ хуулийн 59.3-т зааснаас гадна хуульч эрдэмтэд, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийн үндсэн багш нарын төлөөлөл арав, хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр хоёр байна.

65.3.Хуульчдын холбоо нь хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг үүргээ магадлан итгэмжлэх комисс байгуулах замаар хэрэгжүүлнэ.

## **66 дугаар зүйл.Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх**

66.1.Хууль зүйн сургууль Дээд боловсролын тухай хуульд заасан шаардлагаас гадна Хуульчдын холбооноос тогтоосон шаардлагыг хангасан байна.

66.2.Хуульчдын холбоо энэ хуульд заасан хуульчийн шаардлагыг хангуулах зорилгоор хууль зүйн сургуульд дараахь шаардлагыг тогтооно:

66.2.1.хууль зүйн боловсролын зохистой хөтөлбөрийн стандарт;

66.2.2.хууль зүйн сургуулийн багшлах бүрэлдэхүүний стандарт;

66.2.3.хууль зүйн сургуулийн боловсролын орчны стандарт;

66.2.4.хуульчийн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн стандарт;

66.2.5.хууль зүйн сургуулийн оюутны заавал эзэмшсэн байх мэдлэг, ур чадварын стандарт.

66.3.Хуульчийн мэргэжлийн боловсролыг эзэмшиж, хуульчаар бэлтгэгдэж байгаа оюутан төгсөхдөө 120 багц цагийг хангасан байх ба оюутны суралцах хугацаа дөрвөн жилээс багагүй байна.

66.4.Энэ хуулийн 66.3-д заасан багц цаг нь Хуульчдын холбооны баталсан хууль зүйн боловсролын зохистой хөтөлбөрийн мэргэжлийн хичээлийн агуулгаар илэрхийлэгдэнэ.

66.5.Магадлан итгэмжлэх комиссын дүрэм, хууль зүйн сургуульд тавигдах нэгдсэн шаардлага, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэлийн төлбөрийн хэмжээг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

66.6.Магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэлд нөлөөлөхүйц өөрчлөлт орсноос бусад тохиолдолд 6 жил тутамд дахин хянана.

66.7.Магадлан итгэмжлэл хийлгэхээр хүсэлт гаргасан хууль зүйн сургууль энэ хуулийн 66.2-т заасан нэгдсэн шаардлагын дийлэнхи шаардлагыг хангасан бөгөөд цаашид 2 жилээс дээшгүй хугацааны дотор бүх шаардлагыг хангах тухай үндэслэл бүхий

төлөвлөгөө, хүсэлт ирүүлсэн тохиолдолд хууль зүйн сургуулийг тодорхой болзолтойгоор магадлан итгэмжилж болно.

66.8.Хууль зүйн сургууль энэ хуулийн 66.7-д заасан хугацаанд хууль зүйн сургуульд тавигдах нэгдсэн шаардлагыг бүрэн хангасан бол тухайн сургуульд магадлан итгэмжлэл олгоно.

### **67 дугаар зүйл.Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, бодлогын нөлөөлөл хийх**

67.1.Хууль санаачлагчийн хүсэлтээр хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажлыг Ажлын алба зохих хороодтой хамтран зохион байгуулна.

67.2.Хууль зүйн бодлогын асуудлаар хуульчдын байр суурийг Хуульчдын холбоо төлөөлнө.

67.3.Хуульчдын холбоо бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах асуудлыг Ажлын албаараа дамжуулан хэрэгжүүлэх ба түүний дэргэд Зөвлөхүүдийн зөвлөл ажиллана.

67.4.Энэ хуулийн 67.3-т заасан Зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүн одоо эрхэлж байгаа ажил нь давхар ажил эрхлэлтээр хязгаарлагдаагүй бол Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч,Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүн, Улсын Их Хурал, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан хуульчдаас бүрдэнэ.

67.5.Хуульчдын холбоо дэргэдээ бодлогын асуудлаар дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний бүтэцтэй байж болно.

67.6.Энэ хуулийн 67.3-т заасан Зөвлөхүүдийн зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц, бүрэлдэхүүнийг Зөвлөл батална.

### **68 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх**

68.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг Хуульчдын холбоо зохион байгуулна.

68.2.Энэ хуулийн 68.1-д заасан сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх бөгөөд уг зард нэр дэвшүүлэх болзол, журам, нэрээ дэвшүүлэхийг хүссэн этгээдийн өргөдлийг хүлээн авах, бүртгэх, нэр дэвшигчийг шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон мэдээлэл байна.

68.3.Хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх эрхтэй.

68.4.Энэ хуулийн 68.3-т заасан хуульч /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд өрсөлдөхөөр нэр дэвшихийг хүссэн өргөдөлдөө доор дурдсан баримт бичгийг хавсаргана:

68.4.1.Монгол Улсын иргэний үнэмлэхийн хуулбар;

68.4.2.хуульчийн зөвшөөрлийн хуулбар;

68.4.3.хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг.

68.5.Ажлын алба энэ хуулийн 68.3-т заасан шаардлагыг өргөдөл гаргагч хангаж байгаа болон өргөдөлд хавсаргасан баримт бичиг үнэн зөв эсэхийг шалгасны үндсэн дээр түүнийг бүртгэж, энэ тухай зөвлөлийн болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

68.6.Хуульчдын холбооны Зөвлөл өргөдөл гаргагч нэг бүрээр хэлэлцэн нууцаар санал хурааж, олонхийн саналаар гурваас доошгүй нэр дэвшигчийн нэрийг тодруулна.

68.7.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч энэ хуулийн 68.6-д заасан нэр дэвшигчдээс нэгийг нь сонгож, ажлын таван өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

68.8.Энэ хуулийн 68.7-д заасан журмаар томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаарх тайланг Хуульчдын холбоонд жил бүр ирүүлнэ.

68.9.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсон гишүүн хууль зөрчсөн, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Хуульчдын холбооны зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс эгүүлэн татах тухай саналыг Хуульчдын холбооны Ерөнхийлөгчид гаргана.

68.10.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь энэ хуулийн 68.9-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилна.

## **69 дүгээр зүйл.Шүүгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулахад оролцох**

69.1.Хуульд заасан Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны төлөөлөл нэг байна.

69.2.Хуульд заасан шаардлага хангасан хуульч шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргах ба хүсэлтдээ энэ хуулийн 33.4-т заасан баримт бичгийг хавсаргана.

69.3.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу бүх шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана.

69.4.Энэ хуулийн 69.3-т заасан дүгнэлтийг Мэргэжлийн хариуцлагын хороо бие даан гаргаж, битүүмжлэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх бөгөөд Зөвлөл, хороодын дарга, гишүүдээс дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

69.5.Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах, нэр дэвшүүлэх, дүгнэлт гаргах болон энэ хуулийн 69.3-т заасны дагуу дүгнэлт гаргах журмыг Их Хурал батална.

### **70 дугаар зүйл.Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх**

70.1.Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж, Шүүхийн захиргааны тухайн хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт заасан тооны нэр дэвшигчийг шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилуулах саналыг Зөвлөл гаргана.

70.2.Хуульд заасан шаардлага хангасан хуульч шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргах ба хүсэлтдээ энэ хуулийн 68.4-т заасан баримт бичгийг хавсаргана.

70.3.Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах, нэр дэвшүүлэх, дүгнэлт гаргах журмыг Зөвлөл батална.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨРЧИЛД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ**

### **71 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хариуцлага хүлээлгэх**

71.1.Хуульч энэ хууль, Хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг Мэргэжлийн хариуцлагын хороонд мэдэгдэх үүрэгтэй.

71.2.Мэргэжлийн хариуцлагын хороо хуулийн зөвлөхөд энэ хууль, Хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн үндэслэлээр, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчид энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.4, 22.1.5-д заасан үндэслэлээр хуулийн зөвшөөрлийг хүчингүй болгох хариуцлага хүлээлгэнэ.

71.3.Мэргэжлийн хариуцлагын хороо энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.4, 22.1.5-д зааснаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч Хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар Мэргэжлийн хариуцлагын хороо дүгнэлт гаргаж Шүүхийн захиргааны тухай хууль, Прокурорын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Нотариатын тухай хуульд заасан хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

71.4.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.4.1-д заасан үндэслэлээр шүүгчийг огцруулсан, Прокурорын тухай хуулийн 68.1-д заасан үндэслэлээр прокурор ажлаас халагдсан, Өмгөөллийн тухай хуулийн 44.3-т заасан үндэслэлээр өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, Нотариатын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.6-д заасны дагуу нотариатчын нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл нь цаашид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд харшлахуйц бол Мэргэжлийн хариуцлагын хороо энэ хуулийн 72.1.3-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **72 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрөл**

72.1.Энэ хууль болон Хуульчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн хуульчид доор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

- 72.1.1.хаалттай, эсхүл нээлтэй сануулах;
- 72.1.2.хуульчийн зөвшөөрлийг 1-3 жилийн хугацаагаар зогсоох;
- 72.1.3.хуульчийн зөвшөөрлийг хугацаатай, эсхүл хугацаагүй хүчингүй болгох.

72.2.Зөрчил гаргасан хуулийн зөвлөхөд өөрт нь ганцаарчлан сануулахыг хаалттай сануулах, нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ.

72.3.Хуульчийн зөвшөөрлийг хугацаатай зогсоосон бол уул хугацаа өнгөрснөөр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхээ сэргээх хүсэлт гаргах эрхтэй.

72.4.Энэ хуулийн 72.3-т заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээх эсэхийг Мэргэжлийн хариуцлагын хороо шийдвэрлэнэ. Мэргэжлийн хариуцлагын хороо хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхийг нь зогсоосон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээх боломжгүй гэж үзсэн бол зургаан сарын дараа дахин хүсэлт гаргаж болно.

72.5.Хуульчийн зөвшөөрлийг хугацаатай хүчингүй болгох хариуцлага хүлээлгэсэн бол уул хугацаа дуусгавар болсноор хуульчийн шалгалтад дахин орох эрхтэй.

72.6.Хуульчийн зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосон бол хуульчийн шалгалтад дахин орох эрхгүй.

72.7.Энэ хуулийн 72.1-д заасан хариуцлага хүлээлгэхэд хуульчийн гаргасан зөрчил, түүний шинж чанар, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруугийн хэлбэр болон Мэргэжлийн хариуцлагын хороо ач холбогдолтой гэж үзсэн бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

72.8.Хуульч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн бол хариуцлага хүлээлгэхгүй. Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

72.9.Хуульчид энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн нь түүнийг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **73 дугаар зүйл.Маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа**

73.1.Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг хуульчид, иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, гомдол, мэдээллээр хянан шийдвэрлэнэ.

73.2.Энэ хуулийн 73.1-д заасан хүсэлт, гомдол мэдээлэлийг бичгээр ирүүлэх бөгөөд дараахь шаардлагыг хангасан тохиолдолд маргаан үүсгэх үндэслэл болно:

73.2.1.гомдол, мэдээллийг ирүүлсэн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл;

73.2.2.хүсэлт, гомдол, мэдээлэлд холбогдох өмгөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл, харьяалах өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаяг;

73.2.3.хууль, ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаархи мэдээлэл;

73.2.4.хууль, ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзсэн үндэслэл, түүнийг нотлох баримт бичиг, мэдээ, мэдээлэл.

73.3.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хянан шийдвэрлэхдээ доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

73.3.1.хүсэлт, гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгч болон маргаанд холбогдох хуульчаас тайлбар авах;

73.3.2.хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүй, түүний шинж чанар, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал болон маргаанд ач холбогдолтой гэж үзсэн бусад нөхцөл байдлын талаар нэмэлт баримт, мэдээ, мэдээлэл цуглуулах;

73.3.3.хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдэх этгээдээс тайлбар авах;

73.3.4.тусгай мэдлэг шаардах асуудлаар мэргэжлийн байгууллага, шинжээч, мэргэжилтнээс тодорхойлолт, дүгнэлт гаргуулан авах.

73.3.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хоёр сарын дотор хянаж, шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Мэргэжлийн хариуцлагын хороо энэ зүйлд заасан хугацааг дахин нэг удаа хоёр хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

73.4.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа эсэхээс үл хамааран

тухайн хуульчтай холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл ирсэн бол Мэргэжлийн хариуцлагын хороо маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах эрхтэй.

73.5.Хуульчийн мэргэжлийн ёс зүйн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмаар зохицуулна.

73.6.Мэргэжлийн хариуцлагын хороо нь шаардлагатай тохиолдолд хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүйн талаар холбогдох этгээдээс лавлагаа, тодорхойлолт авах, Мэргэжлийн хариуцлагын хороонд ирж тайлбар өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох иргэн, хуулийн этгээд нь үнэн зөв тайлбар өгөх болон Мэргэжлийн хариуцлагын хорооны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

73.7.Мэргэжлийн хариуцлагын хороо энэ хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны сан бүрдүүлж, хариуцлага хүлээлгэсэн хуульчдийн бүртгэл хөтөлнө.

73.8.Мэргэжлийн хариуцлагын хороонд маргааныг хянан шалгах болон шийдвэрлэх чиг үүргийг тус тусдаа субъект хэрэгжүүлнэ.

#### **74 дүгээр зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр**

74.1.Мэргэжлийн хариуцлагын хорооны хуралдаанд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсноор хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

74.2.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хянаж, доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

74.2.1.хуульч энэ хууль, Ёс зүйн дүрмийг зөрчсөн нь тогтоогдсон бол энэ хуулийн 72.1-д заасан хариуцлага хүлээлгэх;

74.2.2.хуульч энэ хууль, Ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй тогтоогдоогүй бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

74.2.3.маргааныг Шүүхийн захиргааны тухай хууль, Прокурорын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Нотариатын тухай хуульд заасан хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд хянан хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр нь хүчин төгөлдөр байгаа бөгөөд энэ хуулийн 71.4-д заасан үндэслэл байхгүй бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

74.2.4.энэ хуулийн 72.8-д заасан хариуцлага хүлээлгэх хугацаа өнгөрсөн бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

74.2.5.зөрчлийг тал бүрээс нь, бүрэн гүйцэт шалгаж тогтоогоогүй гэх үндэслэл байгаа бол нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах.

74.3.Энэ хуулийн 74.2.4-т заасан үндэслэлээр маргааныг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг өмгөөлөгч хүлээн зөвшөөрөөгүй бол маргааныг нийтлэг журмын дагуу хянан хэлэлцэж энэ хуулийн 74.2.1, 74.2.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

74.4.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандана.

74.5.Шүүхэд хандсан бол Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **75 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох зүйл**

75.1.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хуульчдын холбооноос энэ хуулийг зохих ёсоор хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтнаас нөлөөлөх, саад хийх аливаа үйлдлийг хориглоно.

### **76 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих**

76.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах асуудлын хүрээнд Хуульчдын холбооноос явуулж байгаа үйл ажиллагаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлж, хяналт тавина.

76.2.Хуульчдын холбоо Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээ, мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил тутам хүргүүлнэ.

76.3.Хуульчдын холбоо энэ хуулийн Хоёрдугаар бүлэг, 18 дугаар зүйл, 33.1, 58, 66, 72 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны тайланг жил бүр, Их Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааны талаархи тайланг тухай бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

76.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 65.1-д заасан хяналтыг тавихдаа Холбооны бие даасан байдалд нөлөөлөхийг хориглоно.

76.5.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 65.1-д заасны дагуу хяналтыг хэрэгжүүлсний үндсэн дээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи саналаа Засгийн газар, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

### **77 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж**

**зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

77.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**78 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

78.1.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.